



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 27 өдөр

Дугаар A/177

Улаанбаатар хот

**Газар эзэмших, ашиглах эрхийн
дуудлага худалдааг дахин зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, 2025 оны 120 дүгээр тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 188 дугаар тушаал, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны A/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2025 оны A/131 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдаанд ялагч тодроогүй 1 (нэг) байршилд 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр дахин цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ анхны үнийг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010693



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн
А.Т.Т. дугаар захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2-аар)	Газрын анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн төлбөр 10% (төгрөг)
1	БХД 2-р хороо, Хуучин нүүрсний уурхайн баруун урд талд	Жимс жимсгэний усалгаагүй тариалан	273773	4,762,281	476,228.1